

## МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

*Б.Ганзориг\*,  
Д.Начин\*\**

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь эх үүсвэрээс гадна гадаадын менежмент, технологийн хувьд ноу-хауг нэвтрүүлэх, харилцан солилцох боломж олгох, бизнесийн өрсөлдөөнийг идэвхижүүлэх, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх, эдийн засаг, нийгмийн ерөнхий тогтолцоонд эерэгээр нөлөөлөх зэрэг давуу талтай билээ. Мөн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, иргэдийн орлогын түвшинг сайжруулах, татварын суурийг өргөжүүлэх, мэргэшсэн ажилтныг бий болгох зэрэг давуу талтай. Ийм ч учраас гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахын төлөө хөгжлийн түвшингээс үл хамааран бүхий л улс орнууд өрсөлдөж байна.

### **I. Гадаад орчны талаар**

Монгол Улсын төр, засгаас гадаадын хөрөнгө оруулалтанд өндөр ач холбогдол өгсөөр ирсэн бөгөөд тэр нь Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль (МУЗГ, 2002), бусад хууль, тогтоомж болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын болон хоёр талын гэрээ, хэлэлцээрээр баталгаажин хамгаалагдсан байдаг юм.

Монгол Улсын олон улсын эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагаа нь түүний нэгдэн орсон олон улсын олон талт гэрээ хэлэлцээрүүдээр зохицуулагддаг юм. Үүнд 1996 онд нэгдэн орсон “Улс болон бусад Улсын иргэдийн хооронд Хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай 1965 оны Вашингтоны конвенци”, 1997 онд нэгдэн орсон “Олон талын Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах байгууллагын (1985 оны) конвенци”, 1997 онд нэгдэн орсон “Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр”, “Олон улсын бараа худалдах, худалдан авах тухай Венийн конвенци”, 1985 онд нэгдэн орсон “Аж үйлдвэрийн өмчийн эрхийг хамгаалах тухай (Парисын 1883 оны) конвенци”, “Барааны тэмдгийн Олон улсын бүртгэлийн тухай (Мадридын 1891 оны) хэлэлцээр”, 1991 онд нэгдэн орсон “Патентын хамтын ажиллагааны (1970 оны) гэрээ” (Дүгэрсүрэн 1999) зэргийг дурьдаж болно.

\* Б.Ганзориг - Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн дарга

\*\* Д.Начин - мөн агентлагийн ажилтан

Монголын Засгийн газар нь “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай” хоёр талын хэлэлцээрт 33 улстай, “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”-т 39 улстай тус тус гарын үсэг зурсан.

Монгол Улсын Засгийн газраас байгуулсан Худалдааны гэрээ хэлэлцээрүүд, ялангуяа АНУ, Европын Холбоотой байгуулсан худалдааны нэн тааламжтай гэрээнүүд нь ГХО-ыг татахад чухал нөлөө үзүүлж байгаа болно. Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллага /ДХБ/ -д элссэнээс хойш худалдааны бодлогоо 2005 оны 3-р сард анх удаа амжилттай хянууллаа. ДХБ-аас манай худалдааны бодлогыг дүгнэхдээ, худалдааны нээлттэй бодлогын үр дүнд гарсан эдийн засгийн хөгжлийн өсөлтийг сайшаан тэмдэглэж, улмаар төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн тогтолцоонд шилжих явцад ихээхэн дэмжлэг үзүүлсэн ба өнөө үед эдийн засгийн тогтвортой өсөлттэй байгаа бөгөөд инфляцийн түвшин боломжийн хэмжээнд байна. Ингэснээр Монгол Улс нь макроэдийн засгийн тогтворжилтыг хангах үүднээс үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт шилжсэнээр, улмаар эдгээр салбаруудад хөрөнгө оруулалтыг татах ач холбогдолтой болж байгаа юм. Түүнчлэн Дэлхийн Банк, Олон Улсын Санхүүгийн Корпорацитай хамтарч 175 улс орны бизнес эрхлэх хууль тогтоомжид хийсэн Doing Business 2007 судалгаагаар Монгол Улс нь бизнес эрхлэхэд хүндрэл багатай орнуудын эхний 45-д бичигджээ. Мөн НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын илтгэлд Монгол Улсыг ГХО-ын харьцангуй өндөр чадавхитай орнуудын тоонд багтаасан. Эдгээр нь хөрөнгө оруулалтын орчин манай улсад таатай байгааг давхар баталж байна.

Монгол Улс нь Дэлхийн банкны Олон талын Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах агентлагийн /MIGA/ гишүүн учир MIGA-гийн эрсдлийн даатгалд хамрагдах эрхтэй гэдгийг зориуд тэмдэглэх нь зүйтэй.

Монгол Улсын Засгийн газраас хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай тэнцвэртэй, тогтвортой, эрх тэгш, харилцан ашигтай зарчимд тулгуурласан өргөн цар хүрээтэй хамтын ажиллагааг өрнүүлэн хөгжүүлэх талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа тодорхой үр дүнгээ өгч байна.

Манай улс ОХУ-тай харилцаа, хамтын ажиллагаагаа “Сайн хөршийн, уламжлалт түншлэл”-ийн үзэл санааны дагуу явуулж байна. (ГХЯ 2004) 1995 оны 11-р сарын 29-ний өдөр “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”-т, 1995 оны 4-р сарын 5-ны өдөр “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж

ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай гэрээ”-нд хоёр тал гарын үсэг зурсан бөгөөд давхар татварын гэрээ нь 1998 оны 1-р сараас, хөрөнгө оруулалтын хэлэлцээр нь 2006 оны 2-р сараас хүчин төгөлдөр болсон.

Идэвхгүй байдалд ороод байсан Монгол-Оросын харилцааг чанарын шинэ шатанд гаргаж, олон жилийн туршид шийдлээ хүлээж байсан томоохон асуудлуудыг нааштайгаар зохицуулахад ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины 2000 онд, ОХУ-ын Засгийн газрын дарга М.Касьяновын 2002 онд манай улсад хийсэн айлчлал, Монгол Улсын Ерөнхий сайдын 2003 онд ОХУ-д хийсэн айлчлал нь чухал үүрэг гүйцэтгэж, хоёр улсын харилцаанд гарсан нааштай эхлэлийг улам батжуулан, Монгол-Оросын хамтын ажиллагаанд олон жилийн турш шийдвэрлэгдэлгүй хуримтлагдсан “их өр”-ийн гэгдэх асуудлыг нааштай шийдвэрлэхэд бодитой нөлөө үзүүлсэн бөгөөд энэ нь хоёр талын улс төр, эдийн засгийн харилцаанд цоо шинэ уур амьсгал бий болгов. (ГХЯ 2004) Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 онд ОХУ-д хийсэн төрийн айлчлал амжилттай болж, өргөн цар хүрээтэй асуудлыг хэлэлцэн, харилцаа, хамтын ажиллагааны тодорхой тохиролцоонд хүрэв.

Монгол-Хятадын харилцаа, хамтын ажиллагаа бүх чиглэлээр хөгжиж байна. Дээд, өндөр хэмжээний айлчлалууд тогтмолжиж БНХАУ-ын төрийн тэргүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, хоёр улсын Гадаад хэргийн болон бусад яамны сайд нар харилцан айлчлав.

Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг олон хэлбэрээр хөгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, байгалийн баялаг, дэд бүтцийг хөгжүүлэхэд хоёр улс анхаарч, Монгол Улсын цаашдын ирээдүйн хөгжилд тус дэм болохуйц салбарт томоохон зээл тусламж, төсөл хэрэгжүүлэхээр тохиролцсон. 1991 оны 8-р сарын 26-ны өдөр “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”, “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай гэрээ”-нд хоёр тал гарын үсэг зурсан бөгөөд эдгээр нь 1993 оны 1-р сараас хүчин төгөлдөр болсон юм.

Хятад улс хамгийн их ГХО татаж чадсан орон төдийгүй сүүлийн жилүүдэд гадагшаа хөрөнгө гаргаж байна. Үүнийг Монголд оруулж байгаа Хятадын хөрөнгө оруулалтын байдлаас харж болно.

Монгол Улсын гадаад бодлогын нэг чухал тулгуур болох өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлж, тэдгээрийн эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий

болгох зорилт үе шаттай, амжилттай хэрэгжиж байна.

Монгол Улсын гадаад бодлогод АНУ-тай харилцах харилцаа онцгой байр эзэлдэг бөгөөд АНУ-ыг “стратегийн түнш”-ээ гэж үзэж хоёр талын харилцаандаа шинэ алхмууд хийж, идэвхтэй байр суурь баримталж байна. 9.11-ний террорист халдлагад өртсөн хүнд хэцүү үед АНУ-ын Ерөнхийлөгч Монгол Улсын Ерөнхий сайдыг анх удаа хүлээн авч уулзсан, Монгол Улсын Ерөнхийлөгч 2003 онд АНУ-ын Ерөнхийлөгч болон бусад өндөр албаны хүмүүстэй чухал уулзалт хийсэн, АНУ-ын Ерөнхийлөгч 2006 онд Монголд айлчилсан нь АНУ-ын төрийн бодлогод манай улсын орон зайг нэмэгдүүлж, хоёр орны харилцааг улам өргөжүүлэхэд ач холбогдолтой болов. АНУ нь Монгол Улстай нягт түншлэлийн харилцааг хөгжүүлж, ардчилал, зах зээлийн эдийн засгийг бэхжүүлэх талаар манай улсаас авч хэрэгжүүлж буй бодлогыг дэмжиж буй юм.

1991 онд “Худалдааны харилцааны тухай”, 1994 онд “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”-т хоёр тал гарын үсэг зурсан бөгөөд энэ нь 1997 оны 4-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болжээ. Монгол Улсын Ерөнхийлөгч 2004 оны 7-р сард АНУ-д хийсэн айлчлалын үед Худалдааны ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурав.

Япон улстай харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарт өргөн хүрээг хамарч, “Иж бүрэн түншлэл”-ийн үзэл санааны дагуу хөгжиж байна. Японы засгийн газар Монгол оронд өрнөсөн ардчилсан өөрчлөлтийг хоёр ба олон талын шугамаар тууштай дэмжиж, Дэлхийн банктай хамтран Монголд хандивлагчдын уулзалтуудыг удаа дараа зохион байгуулсан бөгөөд үзүүлж буй зээл тусламжийн хэмжээгээр тэргүүлж байна. 1990 оноос хойш нийт хандивлагчдаас манайд үзүүлсэн зээл тусламжийн тэн хагасаас илүү нь Японд ногдож байгаа юм. Японы засгийн газар Монгол Улстай ойрын 5 жилд хамтран ажиллах Хөгжлийн албан ёсны тусламжийн тусгай хөтөлбөр хэрэгжүүлж байна. Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд Японы Ерөнхий сайд Коизумигийн 2006 онд Монголд хийсэн айлчлал нь хоёр орны иж бүрэн түншлэлийн үзэл санааг шинэ шатанд гаргав. Монгол Улсын Засгийн газар нь Япон улсын Засгийн газартай 2001 оны 2-р сарын 15-ны өдөр “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”-т гарын үсэг зурсан нь Японы хөрөнгө оруулалтыг цаашид нэмэгдүүлэх эрх зүйн үндэс, хүчин зүйл болов.

Европын Холбоо, түүний гишүүн орнуудтай тогтоосон харилцааг бататгах, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх үйл хэрэгт манай төр, засгийн удирдлагын түвшинд ЕХ, түүний гишүүн улс

болон Швейцарь, Украин, Турк зэрэг Европын бусад улсад хэрэгжүүлсэн айлчлалууд чухал тгүлхэц боллоо.

Монгол Улс ЕХ-ны 14 улс (ХБНГУ, ИБУИНВУ, Франц, Бельги/Люксембург, Итали, Унгар, Нидерланд, Дани, Польш, Чех, Австри, Литва, Швед)-тай “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”, 11 улс (ХБНГУ, Унгар, Франц, ИБУИНВУ, Бельги, Чех, Польш, Люксембург, Нидерланд, Австри, Итали)-тай “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай гэрээ”-нд гарын үсэг зуржээ.

Монгол-ЕХ-ны Хамтарсан хорооны VII хуралдаанаар худалдаа-хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Монгол Улсыг ЕХ-ны АЛА хөтөлбөрт хамруулах, худалдаа-хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, тарифын хөнгөлөлт, зах зээлийн статустай болох зэрэг асуудлыг хэлэлцэв. ЕХ-ны техникийн хамтын ажиллагааны ТАСИС хөтөлбөрөөс хөгжлийн туслалцааны АЛА хөтөлбөрт 2004 оноос шилжих болсон нь ЕХ-ны зүгээс Монголд хэрэгжүүлэх төслүүдийг илүү урт хугацаанд хэрэгжүүлэх, улмаар манай улсын цаашдын хөгжилд чухал хувь нэмэр үзүүлэх ач холбогдолтой юм. Энд Европын сэргээн босголт хөгжлийн банк манай улсыг зээлжих эрхтэй орнуудын тоонд оруулах шийдвэр гаргасныг тэмдэглэх нь зүйтэй.

ЕХ-ноос 2005 оны 6-р сарын 27-нд 2006-2008 онд мөрдөх тарифын хөнгөлөлтийн журам баталсан бөгөөд “сайн засаглал, тогтвортой хөгжил”-ийн болзлыг хангасан Монгол Улс нь эмзэг эдийн засагтай бусад 13 орны хамт тарифын хөнгөлөлт эдлэхээр болов. Энэхүү шинэ журмаар 7200 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг ЕХ-ны зах зээлд гаалийн татваргүйгээр нэвтрүүлэх болсон нь ГХО-ыг нэмэгдүүлэхэд чухал алхам боллоо.

Монгол Улс, БНСУ-тай дипломат харилцаа тогтоогоод 10 гаруйхан жил болж байгаа ч найрсаг харилцаа нийгмийн амьдралын бүхий л салбарт эрчимтэй хөгжиж, эдүгээ хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа харилцан бие биеэ нөхсөн шинжтэй болж өргөжин хөгжиж байна. Дээд, өндөр хэмжээний айлчлалууд тогтмолжиж, БНСУ манай орны хувьд гурав дахь том хөрөнгө оруулагч бөгөөд худалдааны эргэлтээрээ эхний тавд ордог гол түнш орны нэг болоод байна.

Монгол Улсын Ерөнхий сайд БНСУ-д албан ёсоор айлчлах үеэр “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай” хоёр орны засгийн газар хоорондын хэлэлцээрт 1991 оны 3-р сарын 28-ны өдөр гарын үсэг зурж мөн оны 4-р сарын 30-ны өдрөөс эхлэн

хүчин төгөлдөр болсон нь БНСУ-ын хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн үндэс, хүчин зүйл болсон байна.

Монголд үйл ажиллагаа явуулж байгаа ГХО-тай компаниуд дахин хөрөнгө оруулж байгаа нь Монголд хөрөнгө оруулах боломж, бизнесийн үйл ажиллагаа явуулах муугүй нөхцөл байгааг харуулсан, ГХО-ыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийн гадаад харилцаагаа өргөжүүлэх, ГХО-ыг татахад чиглэлсэн гадаад бодлогыг хэрэгжүүлэх, тодорхой үйл ажиллагаа явуулж ирсний үр дүнд Монголыг сонирхох, тухайлбал хөрөнгө оруулагч улс орны тоо ч өсөн нэмэгдсэн юм. 1990 онд зөвхөн 2 орон хөрөнгө оруулж байсан бол 1994 онд 20, 1996 онд 41, 2000 онд 65, 2006 онд 93 орны хөрөнгө оруулагчид Монголд бүхий л салбарыг хамран эдийн засгийн үйл ажиллагаа явуулж байна.

Хөрөнгө оруулагчдын харьяалагдах улс орноор авч үзвэл Зүүн Хойд Ази, Хойд Америкийн хөрөнгө оруулагчид түлхүү хөрөнгө оруулалт хийснээс БНХАУ-ын хөрөнгө оруулагчид Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалтын жагсаалтыг тэргүүлж, Канад, БНСУ, Япон, АНУ, ОХУ болон бусад орны хөрөнгө оруулагчид дараагийн байруудад орж байна. (ГХОГХА 2006)

2006 оны эцсийн байдлаар 1990 оноос хойш өссөн дүнгээр 1.8 тэрбум ам.долларын хөрөнгө гадаадын улс орнуудаас бүртгэгдсэн бөгөөд зөвхөн 2000-2006 онд үүний 80 гаруй хувь орсон байна. 2005 оноос жилд 300 сая гаруй ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орох болсон нь 1996-1999 оны дунджаас бараг 6 дахин их байна.

Ийнхүү Монголын төр, засгаас сүүлийн жилүүдэд ГХО-ыг урамшуулан татахад шууд чиглэсэн гадаад бодлого, холбогдох арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлж байсан нь хөрөнгө оруулагчдын итгэл үнэмшлийг бэхжүүлэх бодит үндэс суурь болж, ГШХО жилээс жилд өсч, эдүгээ ДНБ-ий бараг 20 хувьтай тэнцэх хэмжээнд хүрээд байгаа, цаашид улам өсөн нэмэгдэх хандлага байгааг дараахь хүчин зүйлүүдтэй холбож болохоор байна. Үүнд:

- ◆ Гадаадын хөрөнгө оруулагчдын ихэд болгоомжилдог байсан Монголын төсөвт санхүүгийн тооцоолоогүй дарамт гарч ирэн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэх нэгэн *эрсдэл* - Монгол Улс, ОХУ-ын хооронд олон жил дамнан яригдсаар ирсэн *их өрийн асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн* (ГХЯ 2004),

- ◆ Эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд тогтворжив. 2003 оны 11-р сард Токиод зохиогдсон Монголд хандивлагч орнуудын зөвлөлдөх уулзалтаас манай орныг шилжилтийн үеэс өсөлтийн үе шатанд орлоо гэж дүгнэсэн (ADB) бөгөөд ДНБ-ий өсөлт 2005 онд 6,2

хувьд хүрсэн (ҮСГ2006), 2006 онд урьдчилсан байдлаар 8,4 хувьд хүрчээ.

- ◆ НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлаас хийсэн судалгааны үр дүн болох 2003 оны Дэлхийн хөрөнгө оруулалтын тайланд Монгол Улс нь ГШХО орох харьцангуй өндөр чадавхтай орнуудын тоонд анх удаа багтсан бөгөөд энэ үзүүлэлт хадгалагдсаар байна. (UNCTAD 2003, 2005)

- ◆ Нөгөөтэйгүүр Европ, Америк төвтэй дэлхийн уламжлалт зах зээл Ази, тэр дундаа БНХАУ руу чиглэн шилжиж байгаа үед энэхүү том зах зээлд нэвтрэх үүднээс гадаадын хөрөнгө оруулагчдад худалдааны либерал бодлого, тогтолцоотой Монгол орон, түүний эрдэс баялгийн нөөцийг сонирхох сонирхол нэмэгдсэн явдал юм .

- ◆ Саяхан болж болж өнгөрсөн Монголын гадаад түншүүдийн Техникийн уулзалтын үед 2015 он хүртэлх хугацаанд Монголын Үндэсний хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд 10 тэрбум ам.долларын ГШХО-ын хэрэгцээ, шингээх чадвар бий гэж дүгнэсэн, Үйлдвэр худалдааны сайдын хийсэн яриа хэлэлцээрүүдийн үед үндэстэн дамнасан корпорациудаас ихээхэн хэмжээний (10, 30-40 тэрбум ам.долларын) хөрөнгө оруулалт хийхээ мэдэгдсэн зэрэг болно.

Иймд цаашид Монголд бизнес эрхлэх, ГХО-ыг түлхүү оруулах таатай орчин бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхийн сацуу улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа ГХО-ыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад сурталчилгаанд улам илүү ач холбогдол өгөх нь ялангуяа ГХО-ын төлөө өрсөлдөөн нэмэгдэж байгаа, манай орны зах зээл, эдийн засгийн хэмжээ бага зэрэг хүчин зүйлээс шалтгаалан зайлшгүй шаардлага бий болоод байна. Тэгэхдээ ГХО-ыг тодорхой салбар, бүтээгдэхүүн, үйлчилгээний салбарт нарийвчлан хандуулах, шинэ дэвшилтэт технологи дамжуулан авах, нутагшуулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд анхаарах нь чухал.

## **II. Дотоод орчны талаар**

Монгол Улсын төр, засгаас улс орны хөгжилд ГХО-ын ач холбогдлыг ямагт өндөрт тавьж ирсэн бөгөөд ийм ч учраас зах зээлийн нөхцөлд аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах анхны хуулиудын нэг “БНМАУ-ын Гадаадын хөрөнгө оруулах тухай хууль” байв. (БНМАУ 1990) 12 зүйлтэй энэ хуульд “Гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага” (ГХОБ), “Гадаадын оролцогч”, “Монголын оролцогч”, “Үүсгэн байгуулах баримт бичиг”-ийг тодорхойлж, ГХО-ын эрхийн баталгаа, хөрөнгө оруулах хэлбэрийг зааж өгснөөс гадна ГХОБ байгуулах журам, түүний үйл ажиллагааны зохицуулалтын тухай асуудлыг тусгасан байдаг.

Хэдийгээр 1990 оны хуульд ГХО-ын эрх зүйн баталгаа, үйл ажиллагааны зохицуулалтын үндсэн элементүүд тусгалаа олсон боловч, ГХОБ-аас төлөх татварын хувь хэмжээ, хөнгөлөлт чөлөөлөлтийн нөхцөл тодорхой тусгагдаагүй, ГХОБ байгуулах шийдвэрийг Сайд нарын зөвлөл (Засгийн газар)-өөс гаргадаг хүндрэл байв. Эдгээр асуудлуудыг боловсронгуй болгох үүднээс 1993 онд энэ хуульд зохих нэмэлт өөрчлөлт оруулсан юм. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Дээд шүүхээс гаргасан хуулийн тайлбар, эрх бүхий сайдын тушаалаар батлагдсан журам, зааврыг мөрдлөгө болгон ажиллаж “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хууль”-ийг хэрэгжүүлж эхэлсэн юм.

Энэ хуулиар гадаадын хөрөнгө оруулагчид нь Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхээс бусад хүрээнд, нутаг дэвсгэрт ГХО-ыг дангаар буюу хамтран хийх боломжоор хангагдсан бөгөөд ГХО-ыг нийгэмчлэх, хууль бусаар хураан авахыг хориглоно. Гадаадын хөрөнгө оруулагчдад оруулсан хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахад Монголын хөрөнгө оруулагчдад олгогдоос дутуугүй тааламжтай нөхцөл олгох гэх зэрэг урамшуулал үзүүлдэг. Монгол Улсын Засгийн газар нь гадаадын хөрөнгө оруулагчдад орлогын албан татварын тодорхой хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлдэг.

2002 оны 1-р сард Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдан гарах хүртэл 1993 оны хуульд нэг бус удаа өөрчлөлт хийж байв.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай 1993 оны хуулийг хэрэгжүүлэх эрх үүргийг тухайн үеийн Худалдаа, үйлдвэрийн яаманд олгогдсон байдаг боловч УИХ-ын 1996 оны “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” 40 дүгээр тогтоолоор уг яам татан буугдсан юм.

Хэдийгээр ХҮЯ-ыг татан буулгасан боловч Засгийн газраас ГХО-ын асуудалд өндөр ач холбогдол өгч, тус асуудлыг эрхлэх засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустайгаар Гадаадын хөрөнгө оруулалтын газрыг УИХ-ын 1996 оны дээр дурьдсан тогтоолоор засгийн газрын бүтцэд Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд анх байгуулж дараа нь УИХ-ын 1998 оны 84 дүгээр тогтоолоор Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг болгон Гадаад харилцааны сайдын, УИХ-ын 2000 оны 32 дугаар тогтоолоор Үйлдвэр, худалдааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд тус тус өөрчлөн зохион байгуулсан болно.

Гадаадын хөрөнгө оруулагчдад олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг (заримыг нь хасч) холбогдох хуульд суулгасан, ГХО-ын



бодлогыг хэрэгжүүлэх бие даасан агентлаг байгуулсан боловч зарим доголдол гарч байв. Гадаадын хөрөнгө оруулагчдад олгодог татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тухай заалтуудыг нэг хуулиас үзэх боломжгүй болж хэд хэдэн хуулийг судлах шаардлагатай болсон.

Хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулагчдын тоо эрс өсч, өргөжин тэлж байгаа бизнесийн үйл ажиллагаа, тэдгээрийн эрх зүйн зохицуулалт, гадаад, дотоодын байгууллагуудын уялдаа холбоо зэргээс шалтгаалан ГХО-ын бодлого, хэрэгжүүлэлтийн асуудлыг 1993 оны хуулийн хүрээнд үргэлжлүүлэн авч явахад бэрхшээл учрах болов.

Хэрэгжүүлэгч агентлагийн эрх үүрэг хуулинд тодорхой тусгагдаагүй учир ГХО-ын бодлогын хэрэгжилтэнд зарим бэрхшээл тулгарч байв. Тухайлбал, татвар, гаалийн болон бусад холбогдох байгууллагууд нь гадаадын хөрөнгө оруулагчтай холбогдолтой аливаа асуудалд өөр өөрийн байр сууринаас хандах, түүгээр үл барам ГХО-тай холбогдол бүхий хууль эрхийн асуудлаар ч уг асуудлаар үүрэг хүлээж байгаа байгууллагын саналыг тусгалгүйгээр Засгийн газрын болон УИХ-ын хуралдаанд асуудал оруулан шийдвэрлүүлж байсан нь хөрөнгө оруулагчдад ойлгомжгүй байдал бий болгож байв. Тухайлбал, ГХО-ын тухай хуулийн 18, 19, 20 заалтыг хүчингүй болгосон зэргийг дурьдаж болох юм. Мөн энд нэг зүйлийг тодруулан хэлэхэд хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын эрх үүрэг тодорхой заагдаагүй байх нь гадаад талд ч ГХО-ын тааламжгүй орчинг бий болгох үр дагаварыг агуулж байсан юм. Судалгаанаас ГХО-ын асуудлыг хариуцсан байгууллагын статус тодорхой, хөрөнгө оруулагчтай холбогдолтой аливаа асуудлаар шуурхай шийдвэр гаргаж чадах эрх мэдэл бүхий байгууллагатай улс орон ГХО-ыг амжилттай татаж хөгжлийн тодорхой түвшинд хүрч чадсан нь харагдаж байна.

ГХО-ыг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлэх үйлчилгээг сайжруулах зорилгоор Засгийн газрын 1999 оны 155 дугаар тогтоолоор “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн зарчмыг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан юм. (МУЗГ 1999) Энэ тогтоолын заалт нь гадаадын хөрөнгө оруулагчдад олон шат дамжлагыг халсан бүх төрлийн түргэн шуурхай үйлчилгээ, тэдгээртэй тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлаар зөв зүйтэй хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, шийдвэр гаргах, шаардлагатай мэдээллээр үйлчлэх, бизнесийн үйл ажиллагааг тогтвортой хангахад туслалцаа үзүүлэх зорилготой бөгөөд үүнийг тус агентлагийн Нэг цэгийн үйлчилгээ төв тодорхой хэмжээнд ханган хэрэгжүүлж байгаа болно.

Манай орны хөрөнгө оруулалт, бизнес эрхлэх орчин сайжирч гадаадын хөрөнгө оруулалт жил тутам нэмэгдэж байгаа боловч зах зээлийн багтаамж бага, дэд бүтэц сул хөгжсөн, далайд гарцгүй зэргээс

шалтгаалан хөрөнгө оруулалтын боломж хязгаарлагдаж байгаа юм. Нөгөөтэйгүүр, улам бүр даяарчлагдаж байгаа дэлхийд хөрөнгийн урсгал нь аль болох эрх зүйн тогтвортой, таатай нөхцөл, орчин бүхий хөгжиж байгаа улс орон руу чиглэж, энэхүү урсгалыг үндэстэн дамнасан корпорациуд удирдан зохицуулах хандлагатай болов. Өөрөөр хэлбэл, ГХО-ыг татах өрсөлдөөн улам ширүүн болж, хууль эрх зүйн тогтвортой орчин шаардах боллоо. Хөрөнгө санхүүгийн нөөц бололцоотой улс орнууд ч гэсэн орчин үеийн менежмент, маркетинг, техник, технологи эцсийн бүлэгт өрсөлдөх чадварыг бий болгох ГХО-ыг эрэлхийлэн өрсөлдөж байна.

Энэ бүх байдалд үндэслэн 1993 оны хуульд холбогдох нэмэлт өөрчлөлт оруулж уг хуулийг хэвээр нь үлдээхийг зүйтэй гэж үзээд дараахь нэмэлт өөрчлөлт оруулав. Үүнд:

1. “Хөрөнгө оруулалтын гэрээ”, “гадаадын байгууллагын төлөөлөгчийн газар”, “гадаадын хуулийн этгээдийн салбар нэгж”-ийг бүртгэх, үйл ажиллагааг зохицуулах,

2. Хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэрийг өргөжүүлэх, тухайлбал, дэлхийд нэртэй бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ГХО-ыг татахын тулд “франчайзын хэлбэрийн хөрөнгө оруулалт” хийх боломжийг олгох,

3. Монгол Улсын төр, захиргааны байгууллагуудын бүтцийн өөрчлөлт, хууль тогтоомжийн шинэчлэлтэй уялдуулан ГХО-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ГХО-ыг хэрэгжүүлэх байгууллага гэж салгаж, тэдгээрийн ГХО-тай холбогдсон бүрэн эрхүүдийг тогтоон заах,

4. Ихээхэн хэмжээний хөрөнгө оруулсан гадаадын хөрөнгө оруулагчидтай тогтвортой байдлын гэрээ байгуулж болох зэрэг эдгээр болно.

ГХО-ын чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор ГХО-тай аж ахуйн нэгжийн хөрөнгийн 25 хувиас доошгүй нь гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгө байхаар тусгав. Гадаадын хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг тогтвортой байлгах нь хөрөнгө оруулагчийг татах, томоохон төслүүдийг хэрэгжүүлэх сонирхол төрүүлэх, үр ашигтай бизнесийг тодорхой хугацаанд эрхлэх баталгаа болно хэмээн үзэж хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээг байгуулах асуудлыг тусгасан юм. Гэрээний хугацааг оруулсан хөрөнгийн хэмжээтэй уялдуулан ялгавартай тогтоов.

Орлогын албан татварын хөнгөлөлтийг хэвээр үлдээхийн хамт түүнд дэд бүтцийн болон нэн чухал ач холбогдол бүхий зарим салбарт, тухайлбал, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, ердийн ашигт малтмалаас бусад эрдсийн түүхий эд

олборлох, боловсруулах, мэдээллийн технологи, программ хангамжийн чиглэлээр хөрөнгө оруулах гадаадын хөрөнгө оруулагчдийг хамааруулах нь зохистой гэж үзсэн. Монгол Улсын Засгийн газраас уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд бүтэц, аялал жуулчлалын салбарыг ГХО-ыг татах тэргүүлэх ач холбогдол бүхий салбарууд гэж тодорхойлж, дээрх салбаруудад хөрөнгө оруулалт хийхэд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дүрмийн санд оруулах технологийн тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлж байв. Засгийн газрын 2001 оны 140 дүгээр тогтоолоор баталсан Гадаадын хөрөнгө оруулах ач холбогдол бүхий тэргүүлэх салбарын жагсаалтын дагуу үр тариа, эрчимжсэн мал аж ахуй, нүүрс, газрын тос, ашигт малтмал олборлолт, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэхмэл, үслэг эдлэл, арьс шир боловсруулалт, мод, модон эдлэл, төмөрлөг, химийн үйлдвэрлэл, хоёрдогч түүхий эдийн боловсруулалт, дэд бүтцийн зарим салбар, аялал жуулчлал зэрэгт хамаарагдах ГХО-тай аж ахуйн нэгжийн дүрмийн санд гадаадаас орж ирж буй технологийн зориулалттай тоног төхөөрөмж нь НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөгдөнө. Санхүү, эдийн засгийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын хамтарсан тушаалаар Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт хөрөнгө оруулж буй ГХО-тай аж ахуйн нэгжийн технологийн зориулалтаар ашиглах, угсарч суурилуулах тоног төхөөрөмж, хүнд механизмын жагсаалтыг баталж, тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулж байв.

ГХО-тай аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн холбогдох заалт, тухайн аж ахуйн нэгжийн өмнөх оны үйл ажиллагаанд үндэслэн Татварын газрын даргын тушаалаар шийдвэрлэдэг. 2001-2004 онуудад жилд дунджаар 50 орчим аж ахуйн нэгж орлогын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн байна. Тэдгээрийн ихэнхэд нь бүтээгдэхүүнийхээ 50-иас дээш хувийг экспортлодог гэсэн заалтанд хамрагдаж, цөөн тооны компаниудад бусад заалтаар хөнгөлөлт, чөлөөлөлт олгожээ. ГЕГ-аас гаргасан мэдээгээр 2001-2004 онуудад жилд дунджаар 100 орчим аж ахуйн нэгж гааль, НӨАТ-ын чөлөөлөлт эдэлсэн байна. Эндээс ГХО-тай аж ахуйн нэгж л бол татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэдэг гэдэг нь ташаа ойлголт болохыг харж болно.

Нөгөөтэйгүүр, манай бизнес эрхлэгчдийн санхүүгийн бололцоо харьцангуй нэмэгдэж, хөрөнгө оруулалтын боломжуудыг ашиглан хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл өссөн, үүнтэй уялдаж хөрөнгө оруулагчдад адил тэгш хандахыг шаардах болсон, жижиг дунд үйлдвэрлэл нь ядуурлыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл гэж

үзсэн зэрэгтэй холбогдож татварын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах шаардлага гарч ирсэн болно.

Хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор УИХ-аас Татварын тухай багц хууль, Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн баталлаа. 2007 оны эхнээс хэрэгжих Татварын шинэчилсэн хуулиуд нь улс орны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, ажлын байр шинээр бий болгох, албан бус эдийн засгийг бууруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад ижил нөхцөл олгоход чиглэгдэж олон улсын жишигт ойртсон арга хэмжээ боллоо. Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн баталснаар манай орны эрдэс баялгийг илүү зохистой ашиглахад чиглэгдэж байна. Хөрөнгө оруулалтын таатай нөхцөл болох эдийн засгийн чөлөөт бүс, аж үйлдвэрийн парк байгуулах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал боловсрогдож байна.

ААНБОАТ-ын шинэ хуульд татварын доод хэмжээг 15%-аас 10%, дээд хэмжээг 30%-аас 25% болгон бууруулж, дээд шатлалын албан татвар ногдох орлогын босгыг 100 сая төгрөгөөс 3 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэнээр татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийн 99% нь “татварын нэг шатлалтай” нөхцөлд үр ашигтай үйл ажиллагаа явуулах боломжийг олгов. Аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагааны зардлаа улам багасгах боломжийг бүрдүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор хөрөнгө оруулалтыг татвараас чөлөөлөх, шинээр байгуулагдсан буюу түр хугацаагаар хүнд нөхцөлд буй аж ахуйн нэгжүүдийг дэмжиж алдагдлыг дараа жил шилжүүлэн тооцох боломжийг бүрдүүлсэн. Засгийн газрын 2006 оны 311 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт”-ыг баталж, эдгээр салбарт хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжүүдэд орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх журам боловсруулж мөрдүүлэхээр болсон байна. Энэ тогтоолоор Засгийн газрын дээр дурьдсан 2001 оны 140 дүгээр тогтоолыг 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчингүй болгов.

ХАОАТ-ын шинэ хуульд одоогийн 10, 20, 30 хувийн гэсэн 3 шатлалтай хүн амын орлогод ногдох татварыг 10%-ийн нэг шатлалтай болгож, албан татвар төлөгчийн хүн амын орлогод ногдох жилийн албан татвараас 48,000 төгрөгийн албан татварын хөнгөлөлт үзүүлдэг байсныг 84,000 төгрөг болгож нэмэгдүүлэв. Ингэснээр амьжиргааны доод түвшингийн хүн амын 30 орчим хувийг эзэлж буй иргэд татвараас чөлөөлөгдөхөөс гадна бага орлоготой иргэдийн гуравны нэг мөн татвараас чөлөөлөгдөх юм. Татварын 8 төрлийн хувь хэмжээг 4 болгосноор татвар төлөгчдөд дарамт учруулдаг татварын үйл ажиллагааны хүнд суртлыг багасгах, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн

үйл ажиллагааны зардлыг улам багасгах боломжийг бүрдүүлэх, шууд бус орлогыг тодорхойлж албан татвар ногдох орлогод багтааснаар татвараас зайлсхийх боломжийг бууруулах, харилцан хамаарал бүхий этгээдийн ажил гүйлгээг нарийвчлан тодорхойлж татвараас зайлсхийх боломжийг багасгах, хуулийг олон улсын жишигт ойртуулав.

НӨАТ-ын шинэ хуульд НӨАТ-ын хэмжээг 15%-аас 10% болгон бууруулж, татвараас чөлөөлөх олон заалтыг хүчингүй болгов. Харин Монгол Улсын Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах зарчмын дагуу газрын тосны үйл ажиллагаатай холбогдох тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгслэл, бензин, дизелийн түлшинд ноогдуулах НӨАТ-ыг урьдын адил чөлөөлж байхаар үлдээв. Түүнчлэн НӨАТ-ыг хийн түлш, хийн түлшний сав, тусгай зориулалтын тоног төхөөрөмж, машин механизм, хэрэгслэлд ногдуулахгүй байх бөгөөд ийм бараа бүтээгдэхүүний жагсаалтыг Засгийн газраас батална.

Онцгой албан татварын шинэ хуульд төлбөрт таавар, барьцаат тоглоомд ашигладаг зарим техник хэрэгсэлд сар тутам татвар ногдуулах, импортын автомашинд татвар ногдуулах аргачлалыг өөрчлөн, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх, ингэснээр агаарын бохирдолд нөлөө үзүүлэх хуучин машины импортыг хязгаарлах, ихэнх согтууруулах ундаанд ногдох татварын хэмжээг нэмэгдүүлэхээр заасан байна.

Монгол Улс үндсэндээ бүх бараанд 5 хувийн импортын татвар ногдуулж байна. Цэвэр үүлдрийн амьд мал, мэдээллийн технологи, хүн эмнэлгийн болон мал эмнэлгийн зарим төрлийн тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги импортын татваргүй. Гурил, хүнсний ногоонд улирлын чанартай импортын татвар ногдуулдаг.

Түүхий ноолуур, тэмээний ноос, ямаа, ишигний арьс, дүнс гуалин, хаягдал хар төмөрлөг, хаягдал хөнгөн цагаан зэрэг цөөн нэрийн түүхий эдэд экспортын татвар ногдуулдаг.

Ийнхүү татварын хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын татварын хөнгөлөлт, амралтын ялгавартай байдлыг арилгаж хуулийг олон улсын жишигт ойртуулснаас гадна татварын орчинг олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц хэмжээнд хүргэж, ажлын байр бий болгох, жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжсэн арга хэмжээ болох учиртай. Үүнийг худалдааны тааламжтай нөхцлүүдийг, тухайлбал ЕХ-ны зах зээлд Монголд үйлдвэрлэсэн 7200 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг гаалийн татваргүй оруулах (GSP+) нөхцлийг үр дүнтэй ашиглахтай хослуулан хэрэгжүүлэх нь онцгой ач холбогдолтой байна.

Эцэст нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ГХО-тай компаниуд нь өнөөдрийн байдлаар өссөн дүнгээр 80 гаруй мянган

ажлын байр бий болгож, сүүлийн 4 жилд Монголын нийт экспортын тал орчим хувийг гүйцэтгэж, төсөвт 40 орчим тэрбум төгрөгийн татварын орлого оруулж байсан бол 2004 онд 60,7 тэрбум, 2005 онд 81,5 тэрбум төгрөгийн татварын орлого оруулж байгаагаас гадна үйлдвэрлэл, үйлчилгээний бусад салбар (цахилгаан, дулаан, холбоо, тээвэр зуучийн гэх мэт)-ыг ч дэмжиж байна. 2005 онд гадаад худалдааны нийт бараа эргэлт 16,5 хувиар нэмэгдэж 2,2 тэрбум, экспортын хэмжээ 21,2 хувиар өсч 1053,7 сая ам.долларт хүрч гадаад худалдааны алдагдал 2004 оныхоос 37 хувиар буурсан байна. 2006 оны урьдчилсан дүнгээр гадаад худалдааны тэнцэл анх удаа ашигтай, 40 сая шахам ам.долларын эерэг тэнцэлтэй гарах төлөвтэй байгаа зэрэг нааштай үзүүлэлтүүдэд ГХО-тай компаниудын оруулсан хувь нэмэр, хүчин чармайлт багагүй байна.

### **III. Хөрөнгө оруулалтын цаашдын төлөв байдал**

Хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл болсон дэд бүтцийн найдвартай үйлчилгээгээр дэмжих бодлогыг төр, засгаас дэс дараатай хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч байна. Үүнд мэдээлэл, харилцаа, холбоо, зам тээвэр, эрчим хүчний салбарт дотоод, гадаадын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа цөөнгүй төслүүд чиглэгдэж байгааг дурьдахын хамт банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа ч тогтворжин сайжирч байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Монгол орны хувьд ГХО нь эдийн засгийн тасралтгүй өсөлтийг хангах нэгэн эх сурвалж төдийгүй улам бүр харилцан хамааралтай болж буй дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн интеграцид түлхүү оролцох шинэ боломжийг нээн өгч буй нэн их ач холбогдолтой зүйл мөн билээ. Эдийн засгийн интеграцид оролцоно гэдэг нь хөрөнгө оруулалтын өрсөлдөхүйц орчин, боломжийг бий болгоно гэсэн үг юм.

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 122 дугаар тогтоолын дагуу зохих бэлтгэлийг ханган Хөрөнгө оруулалтын чуулга уулзалтыг манай эдийн засгийн тэргүүлэх ач холбогдол бүхий хүнд үйлдвэр, уул уурхай, хөнгөн үйлдвэр, аялал жуулчлал, хүнс, хөдөө аж ахуй, дэд бүтэц /барилга, мэдээлэл, харилцаа холбоо, эрчим хүч/-ийн салбарын хүрээнд 2006 оны 9-р сард Улаанбатар хотноо зохион байгуулав. Уг чуулга уулзалтыг Монголын Засгийн газар, ҮХЯ, ГХОГХА, Монгол банк, Euromoney бага хурал-аас хамтран зохион байгуулав. Засгийн газраас хөрөнгө оруулалт эрэлхийлсэн 8 салбарын 43 төсөл, хувийн хэвшлийн 40 гаруй төслийг хамтад нь чуулга уулзалтын үед хөрөнгө оруулагчдад танилцуулан сурталчлав. Чуулга уулзалтад 805 төлөөлөгч оролцсоноос гадаадын 425, дотоодын 380 төлөөлөгчид оролцсон байна.

Чуулга уулзалтын үед Эгийн гол, Чаргайтын усан цахилгаан станц, Улаанбаатар-Мандалговь-Оюутолгой-Тавантолгойн чиглэлд эрчим хүч шилжүүлэх төсөл зэрэг дэд бүтэц, банк санхүү, аялал жуулчлалын төслүүд хэлэлцэгдэж яригдсан. Энэ талаар чуулга уулзалтын дараа, ялангуяа Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарын болон сайд нар гадаадад айлчлахдаа хөрөнгө оруулалтын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэж зарим гэрээ, хэлэлцээр хийх, ажлын хэсэг байгуулах зэргээр хэрэгжүүлэх боломжтой бүхий л арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн Үйлдвэр, худалдааны яам, Түлш, эрчим хүчний яам зэрэг яамд хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрөө үргэлжлүүлэн боловсруулж, уулзалт, ярилцлагууд зохион байгуулагдаж байна.

Энэ дашрамд Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (ГХОГХА) нь дотоод, гадаадад нээлттэй, тодорхой хүрээнд танил байгууллага болж чадсан бөгөөд Олон улсын хөрөнгө оруулалтын ассоциаци (WAIPA)-ийн “Хөрөнгө оруулалтыг дэмжих шилдэг агентлаг” 2002 оны шагнал, Newsweek олон улсын сэтгүүлийн “Honoring Award for Excellence” шагналыг 2005 онд тус тус хүртсэн, Олон улсын хөрөнгө оруулалтын ассоциацийн удирдах зөвлөлийн гишүүнээр тус агентлагийн дарга 2001 оноос ажилласан зэргийг тэмдэглэе. Түүнчлэн тус агентлагаас санаачлан CNBC-телевиз, Fortune, Euromoney, Asia Money, Forbes Asia, Business Week, Newsweek, Panorama зэрэг олон улсын нэр хүнд бүхий сэтгүүл, мэдээллийн компаниудаар Монголын тухай, Монголд хөрөнгө оруулах, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх орчин, боломжийн тухай сурталчилгааг байнга явуулдаг болсон юм.

Саяхан болж өнгөрсөн Монголын гадаад түншүүдийн Техникийн уулзалтын үед 2015 он хүртэлх хугацаанд Монголын Үндэсний хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд 10 тэрбум ам.долларын ГШХО-ын хэрэгцээ, шингээх чадвар бий гэж дүгнэжээ. Өөрөөр хэлбэл, 2015 он хүртэл жилд наад зах нь 1 тэрбум ам.долларын ГХО буюу дунджаар 100 сая ам.долларын 10 төсөл хэрэгжүүлнэ гэсэн үг. Сүүлийн үед орос, япон, германы компаниуд ихээхэн хэмжээний (30-40 тэрбум хүртэл ам.долларын) хөрөнгө оруулах сонирхлоо илэрхийлсэн байдлыг тооцвол дээрхээс хэд дахин их хөрөнгө татах, томоохон төслүүд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай болж байна. Үүний тулд цаашид дараах асуудалд анхаарал хандуулахыг Монгол Улсын Ерөнхий сайд УИХ-ын чуулганы 2007 оны 1-р сарын 5-ны өдрийн хуралдаанд хийсэн мэдээлэлдээ цохон тэмдэглэсэн юм. Үүнд:

♦ Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны үзүүлэлтийг бүс нутгийн орнуудын дундаж түвшнээс дээгүүр түвшинд хүргэх,

- ♦ Олон улсын болон дотоодын төрийн бус байгууллагуудаас гаргаж байгаа судалгаа, дүгнэлтэд үндэслэн хөрөнгө оруулалтын орчинд таагүй нөлөөлж буй хүчин зүйлийг цаг тухайд нь тодорхойлон түүнийг цаашид засварлах, сайжруулах арга хэмжээ авч байх,

- ♦ Дунд болон урт хугацаанд аль салбар, ямар чиглэлд ГХО-ыг түлхүү авбал зохих вэ гэдгийг Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусган тодорхойлсон байх,

- ♦ Энэхүү тодорхойлсон жагсаалтын дагуу ГХО-ыг татах бодлогыг орлогын болон гаалийн албан татварын, стандартын, технологийн, боловсон хүчнийг бэлтгэх бодлоготой нягт уялдуулах,

- ♦ ГХО-ыг зөвхөн хөрөнгө, мөнгө гэж үзэлгүйгээр ГХО-ын хамт шинэ мэдлэг, шинэ технологи, ажлын шинэ байрыг дотооддоо шингээн авах бодлогыг хэрэгжүүлэх,

- ♦ Гадаадын хөрөнгө оруулагчдын шаардлагад нийцэхүйц төслүүдийг чанартай, иж бүрнээр, дотоодын эрэлт хэрэгцээ байгаа бүхий л салбар, аймаг орон нутаг, байгууллагын хүрээнд боловсруулж хөрөнгө оруулагчдад танилцуулж байх,

- ♦ Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах хүрээнд зөвхөн хууль эрх зүй, татварын бодлого хамаарахгүй, олон улсын жишгийн дагуу бусад тодорхойлогч үзүүлэлтүүдийг гаргах, судлах, хэлэлцэж, улмаар эдгээр үзүүлэлтүүдийг сайжруулах,

- ♦ Монгол Улсын цаашдын хөгжилд шаардагдах, томоохон хувь нэмэр оруулах боловсруулах үйлдвэрлэл, шинэ техник, технологийн чиглэлийн үзэсгэлэн, яармаг, уулзалт, семинаруудад Монгол Улсаас төрийн болон хувийн хэвшлийн төлөөллийг идэвхтэй, ажил хэрэгч байдлаар оролцуулж хөрөнгө оруулалтын орчны тааламжтай нөхцлийнхөө талаар шинэ хөрөнгө оруулагчдад байнга сурталчилж байх шаардлагатай байна гэжээ.

## **IV. Дүгнэлт**

Монгол Улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин боломжийн, олон улсын жишигт ойртсон, эдийн засгийн өсөлт тогтвортой өсч байгаа болон хөрөнгө оруулалтыг татах гадаад, дотоод сурталчилгааны арга хэмжээнүүд зэргийн үр дүнд Монгол дахь ГХО-ын хэмжээ өсөн нэмэгдэж байна.

2007 оноос эхлэн ГХО-ын хэмжээг өмнөхөөс хэд дахин нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага байгаа, хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлэх учир хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох, төр засгаас энэ тал дээр улам илүү анхаарч холбогдох арга хэмжээнүүдийг авч байх шаардлагатай болж байна.



### Ашигласан хэвлэл

1. Баяртсайхан.Н., 2006, Монгол Улсын Сангийн сайдын Монгол Улсын Засгийн газар болон Гадаад түншлэгчдийн Техникийн зөвлөлдөх уулзалт дээр тавьсан илтгэл, 2006 оны 10-р сарын 9-10-ны өдрүүдэд Улаанбаатар хот.

2. Дүгэрсүрэн.М., Хосбаяр О., 1999, Олон улсын эрх зүй, 1999, МУИС, Олон улсын харилцааны дээд сургууль, Улаанбаатар, Монгол Улс

3. Гадаад хэргийн яам (ГХЯ), 2004, *Монгол Улсын гадаад бодлого, гадаад харилцааны салбарын 2000-2004 оны үйл ажиллагааны тухай* сайд Л.Эрдэнэчулуунаас сэтгүүлчдэд хийсэн мэдээлэл, 2004.03.16., Улаанбаатар

4. Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (ГХОГХА) 2006, *Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тойм 2005*, ГХОГХА, Улаанбаатар

5. Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар (ҮСГ), 2006, Монгол Улсын Статистикийн Эмхтгэл, 2005, ҮСГ, Улаанбаатар

6. МУЗГ, 2000, Төрийн Мэдээлэл, 2000, №20, Дипломат албаны тухай Монгол Улсын хууль, МУЗГ, Улаанбаатар

7. МУЗГ, 2002, Төрийн Мэдээлэл, 2002, №5, Гадаадын Хөрөнгө Оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль, МУЗГ, Улаанбаатар.

8. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, 2006 оны 12 дугаар сарын 22-ны өдөр, Дугаар 311, Журам батлах тухай, Улаанбаатар хот. Монгол Улс

9. ОХУ-ын ГХЯ-ны 2006 оны 2-р сарын 26-ны өдрийн 1160н/1га тоот ноот бичиг

10. The Asian Development Bank (ADB) 2003, *Report on the tenth consultative group meeting on Mongolia*, Tokyo, November 19-21, 2003. ADB.

11. <http://www.adb.org/Documents/Conference/IN309-03.pdf>

12. United Nations Conference on Trade and Development (UNCTAD), 2003, *World Investment Report 2003: FDI Policies for Development: National and International Perspectives*, United Nations, New York and Geneva, 2003

13. United Nations Conference on Trade and Development, 2005, *World Investment Report 2005: Transnational Corporations and the Internationalization of R&D*, United Nations, New York and Geneva, 2005